

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023 оны 05 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 04 дүгээр сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилтийг хамрууллаа.


Байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй буюу үнэлгээнд оруулан тооцох боломжгүй дараах арга хэмжээг хяналтаас хасуулах саналтай байна.

Гадаадын иргэн, харьялалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд “Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авах дэвшилтэд систем /APP/-ийг нэвтрүүлэх, зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийх, хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулна” арга хэмжээ:

Үндэслэл: Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаснаар болон Засгийн газрын 2021 оны 261 дүгээр тогтоолоор уг арга хэмжээг холбогдох байгууллагуудад тусгайлан хариуцуулсны дагуу байгууллагын хяналтаас хасуулах саналтай байна.

Гадаадын иргэн, харьялалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд “Гадаадын иргэн, харьялалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” арга хэмжээ:

Хэрэгжилтийн явц: “Гадаадын иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем” (ISM) дэх мэдээллийг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд тест хэлбэрээр хөрвүүлэх ажлыг эхлүүлж, хөгжүүлэлтийн асуудлаар 04 дүгээр сард гүйцэтгэгч байгууллагатай 2 удаагийн уулзалт зохион байгууллаа.



Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 04 дүгээр сард 30 хувь буюу 1.5 оноотой дүгнэгдлээ.

Хэрэгжилт удаашралтай байгаа нь “Гадаадын иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем” (ISM) дэх мэдээллийг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд тест хэлбэрээр хөрвүүлэх ажлыг эхлүүлж, хөгжүүлэлтийн асуудлаар 04 дүгээр сард гүйцэтгэгч байгууллагатай 2 удаагийн уулзалт зохион байгуулсан, программ хангамжийг үйл ажиллагаанд нэвтрүүлж эхлээгүй байгаатай холбоотой.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.9-д “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, “Аствишн” ХХК-иар шаардлагатай засвар, өөрчлөлтүүдийг түргэн шуурхай хийлгэх, тус компаниас ажлын гүйцэтгэлийг шаардах, хяналт тавих, 2023 хагас жилд программ хангамжийн эхний хувилбарыг үйл ажиллагаанд нэвтрүүлж эхэлсэн байх шаардлагатай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТЭС

